

## ≡ ШИНЭ НОМ ≡



М.Базаррагчаа, Ч.Бямбаханд.  
**Монгол хэл заах арга.**  
Ред. Б.Цэрэндулам, Ж.Даваа.  
Уб., 2017, 222 х. ISBN:  
978-99978-2-193-5.

Орчин үед хэл сурах ба сургах арга зүйд хэл шинжлэлийн шинэ чиг хандлага хийгээд хүний танин мэдэхүй, хэрэглээний үйлийг чухалчлан үзэх болоод байна. Иймд монгол хэлний багш мэргжлээр суралцагсдад зориулсан энэхүү гарын авлагад дээр дурдсан хандлагыг үндэс болгон эх хэлээрээ ярих, бичих ба сонсох, унших мэдрэмж авьяасыг нээх; ярих, бичих, унших, сонсох чадвараа бүтээлчээр хөгжүүлэх; ярих, бичих, унших, сонсох дадал төлөвшилтэй болгох, оюуны ба сурх арга барил эзэмшүүлэх зорилгыг агуулсан болно. Түүнчлэн монгол хэлний сургалтаар бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зүйн хүрээнд эх хэлээрээ унших, бичих, ярих, сонсох чадварыг хэлний онол, хэрэглээний түвшинд хэрхэн сурх хийгээд сургах талаар тодорхой өгүүлж, орчин үеийн зарим аргын талаар дурджээ.

Энэхүү гарын авлага бүтээлийг монгол хэлийг сурч, судалж буй сургч, оюутан, багш нар хийгээд эх хэлээ суралцагч бүхэнд зориулжээ.

\* \* \*



М.Ууганбаяр. **Түгээмэл хэл зүйн зарим асуудал: англи, түрэг, монгол хэлний өгүүлбэр.** Ред. М.Базаррагчаа. Уб., 2018, 164 х. ISBN 978-99978-2-653-4. Нэмж зассан хоёрдугаар хэвлэл.

Энэхүү нэг сэдэвт бүтээлдээ зохиогч англи, түрэг, монгол хэлний цөм өгүүлбэр, гүн ба өнгөн бүтэц, хувиргал, шилжилтийн тухай, уг турван хэлний бүтцийн ба дотоод тийн ялгалын тухай, түүнчлэн орхилтын хэмжигдэхүүний жишээ зэргийг харьцуулан үзсэн судалгаагаа танилцуулжээ. Түүнчлэн өгүүлбэрзүйн онолын орчин үеийн асуудлуудыг англи, түрэг, монгол турван хэлний жишээ баримтаар авч үзсэн байна.

Түгээмэл хэл зүй бол ямар хэлээр ярьж байгаагаас үл хамаараад хүн төрөлхтний нийтлэг өмч байдаг. Өөрөөр хэлбэл түгээмэл хэл зүй нь хүний хэлний мөн чанар бөгөөд хүний бүхий л хэлний махбод шинж чанар болох зарчим, нөхцөл, дүрмүүдийн тогтолцоо хэмээн үздэг. Тиймээс энэ үзэл хандлагын үүднээс дээрх турван хэлийг авч үзэх нь шинэлэг бөгөөд ач холбогдолтой юм. Үүнд энэхүү бүтээлийн анхдагчийн шинж чанар оршино. Ерөөс хэл шинжээчийн судалгааны зорилго аваас ярьж, ойлгож буй хэлээ эх хэлтэн мэднэ гэдэг нь чухамдаа ямар болохыг тодруулах явдал юм. Иймд хэлний судалгаа бол танихуй буюу хүн хэрхэн таниж мэдэж буйн судалгааны нэг хэсэг байдаг билээ. Тиймээс энэ бүтээлийг эх хэлээ нарийвчлан судлахыг хүсэгч, түгээмэл хэлзүйн асуудлыг сонирхон судлагч, монгол хэлтэй төрөл болон төрөл бус хэлнүүдийг харьцуулан судлахыг сонирхогч хэн бүхэнд зориулсан байна.